



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/71

Номгон

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8, 59.1.23. дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.11.1, “Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний 2.3.1, дэх заалт, Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын А/88 дугаар хүсэлтийг хэрэгжүүлэх зорилгоор “Түйн голын жавар 2023” өвлийн наадмын үйл ажиллагаа нь иргэдийн ажил амьжиргаа, орлого ашиг олох нөхцлийг бүрдүүлсэн арга хэмжээ тул орон нутгийн уламжлалт соёл, зан заншил, өвлийн спорт, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хувь нэмэр болж энэхүү өвлийн наадмын үйл ажиллагаанд шаардагдах 2.081,350 (хоёр сая наян нэгэн мянга гурван зуун тавин) төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Тамгын газрын дарга, Төсвийн шууд захирагч (Г.Хүрэлсүх)-д зөвшөөрсүгэй.

3. “Түйн голын жавар 2023” өвлийн наадмын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажилд хариуцлагатай хандаж ажиллахыг Хэвлэл мэдээлэл, олон нийт ажилтан (Д.Отгонтунгалаг)-т, орон нутгийн телевизийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Орлогчид үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ЭНХБАЯР

621010943

Захирамж 2023